

ТУЗ-ИЙН ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО

Баримт бичгийн мэдээлэл	
Баримт бичгийн дугаар:	ЖР-ТУЗ003 /ТУЗ-ийн хурлын 23/11/16-ны өдрийн 23/016 тоот тогтоолын Хавсралт 2/1.0
Баримт бичгийн хувилбарын дугаар:	2023/11/16
Хүчин төгөлдөр болсон огноо:	Нийтэд хүртээмжтэй
Мэдээллийн ангилал:	3
Мэдээллийн түвшин:	ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хорооны дарга
Хариуцагч:	ТУЗ
Хэрэглэгч:	

	Овог нэр	Албан тушаал	Гарын үсэг
Баталсан:	Г.Хатанболд	ТУЗ-ийн дарга	
Боловсруулсан:	Ч.Жаргал	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	

Өөрчлөлтийн түүх

Хувилбарын №	Огноо	Боловсруулсан	Өөрчлөлтийн тайлбар	Хянасан	Баталсан
1.0	2023/11/16	Ч.Жаргал	Анхны хувилбар	ТУЗ-ийн гишүүд	Г.Хатанболд

Түгээлт

Тайлбар
Айтүүлс ХК-ийн цахим хуудсаар хувьцаа эзэмшигч, олон нийтэд нээлттэй түгээгдэнэ. Энэхүү баримт бичгийг хувилбарын дугаараар хянана.

ГАРЧИГ

1. Нийтлэг үндэслэл.....	4
2. ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах.....	4
3. ТУЗ-ийн гишүүдийн сургалт, хөгжил	6
4. ТУЗ-ийн гишүүдийн гүйцэтгэл, тайлагнал	6
5. Бусад.....	6

1. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү баримт бичгээр Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ" гэх/-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, сонгох, залгамж халаа бэлтгэх, сургаж хөгжүүлэх, гүйцэтгэлийг үнэлэх харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү бодлогын баримт бичгийн зорилго нь компанийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах, удирдах албан тушаалтны орон тоо гэнэт буюу төлөвлөгдөөгүйгээр өөрчлөгдсөнөөс үүдэн оролцогч талууд хохирохгүй байх нөхцлийг хангахын тулд эрх бүхий албан тушаалтны залгамж халааг тодорхойлоход оршино.
- 1.3. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо /цаашид "Хороо" гэх/ нь Залгамж халааны бодлогын баримт бичгийн хариуцагч байх ба Хороо нь ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулах, ур чадварыг хөгжүүлэх, үнэлж дүгнэх, залгамж халааг бэлдэх замаар залгамж халааны бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.4. Хороо нь өндөр насны тэтгэвэрт гарах, эсвэл сул орон тоо гарвал нэр дэвшүүлэхүйц шаардлага хангасан нэр дэвшигчийг урьдчилан тодорхойлохын тулд жил бүр судалгаа хийнэ.

2. ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах

- 2.1. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүнд тохирох этгээдийг дараах аргуудын аль нэгээр тодорхойлж сонгон шалгаруулна. Үүнд:
 - 2.1.1. ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах зарыг олон нийтэд нээлттэй зарлаж /цахим хуудас, олон нийтийн сүлжээ, мэдээллийн хэрэгсэл/, шаардлага хангасан нэр дэвшигчийг тодорхойлох;
 - 2.1.2. Компанийн саналын эрх бүхий энгийн хувьцааны 5 /тав/ ба түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлсэн этгээдийг бүртгэх.
- 2.2. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч нь иргэний эрх зүйн бүрэн чадвар, чадамжтай, санхүү, бизнесийн зохих түвшний мэдлэгтэй, хууль тогтоомж, дүрмээр тогтоосон үүргийг бүрэн дүүрэн гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, боловсрол, дадлага туршлагатай Монгол улсын, эсвэл гадаад улсын иргэн байх ба дорх шалгуурыг хангасан байна. Үүнд:
 - 2.2.1. Нягтлан бодох бүртгэл, мэдээллийн технологи, хууль эсвэл холбогдох бусад салбар, шинжлэх ухааны өргөн мэдлэгтэй;
 - 2.2.2. Удирдах албан тушаалд ажиллаж байсан туршлагатай;
 - 2.2.3. ТУЗ-ийн гишүүний ажил үүргийг гүйцэтгэхэд хангалттай цаг хугацааг зориулах боломжтой бөгөөд хүсэлтэй;
 - 2.2.4. Холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичигт тодорхойлсон бусад шаардлага ба шалгуур.
- 2.3. ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч нь дараах нэмэлт шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 2.3.1. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 5 (тав)-аас дээш хувийг эзэмшдэггүй;
 - 2.3.2. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй;
 - 2.3.3. Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй;
 - 2.3.4. Компанитай бизнесийн аливаа холбоогүй;

- 2.3.5. Хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад шаардлага.
- 2.4. Хороо нь ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулахад дараах зарчмыг баримтална.
Үүнд:
- 2.4.1. ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал, хүйсийн зохистой харьцааг хангасан бүтэц бүрэлдэхүүнтэй байна.
 - 2.4.2. Нэр дэвшигчдийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг зэргээр ялгаварлан гадуурхахгүй.
 - 2.4.3. Эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн, засгийн газар, орон нутгийн удирдлагын эсрэг захиргааны зөрчил гаргасан, мөн бизнес, санхүү, татвар, үнэт цаас, хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой зөрчил гаргаж, захиргааны шийтгэл хүлээсэн этгээдийг ТУЗ-ийн гишүүнээр нэр дэвшүүлж сонгохгүй.
 - 2.4.4. ТУЗ-ийн гишүүн нь өрсөлдөгч компанийн тав болон түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч эсхүл гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, ажилтан байж болохгүй.
 - 2.4.5. Компанийн гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдээс ТУЗ-д ажиллах гишүүдийн тоо нь ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэгээс илүү байж болохгүй.
 - 2.4.6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулаагүй үндэслэлээр аливаа хувьцаат компанийн ТУЗ-ийн бүрэн эрх дуусгавар болсноос хойш гурван жилийн хугацаанд тухайн ТУЗ-ийн гишүүн байсан этгээдийн нэрийг дэвшүүлэхээс татгалзана.
- 2.5. Хороо нь шаардлага хангасан нэр дэвшигчдийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэхэд дараах журмыг мөрдөнө. Үүнд:
- 2.5.1. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх этгээдийг сонгохдоо тэдгээрийн боловсрол, ажлын туршлага, ёс зүйн зөрчил гаргаж, гэмт хэрэг үйлдэж байсан эсэх, шүүхээр тогтоосон хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх талаарх мэдээллийг нэг бүрчлэн шалгана;
 - 2.5.2. ТУЗ-ийн хараат бус гишүүнээр нэр дэвшиж буй этгээдийн хараат бус байдлыг хэрхэн тодорхойлсон, бусад компанийн эрх бүхий албан тушаалтнаар ажилладаг эсэх талаар дэлгэрэнгүй танилцуулна;
 - 2.5.3. ТУЗ-ийн гишүүнээр нэр дэвшиж буй этгээд нь сонгогдсон тохиолдолд ажил үүргээ гүйцэтгэхэд хангалттай цаг хугацааг зориулах боломжтой, хүсэл тэмүүлэл бий гэдгээ бичгээр илэрхийлэхийг шаардана;
 - 2.5.4. Компанийн ТУЗ-д долоон жилийн турш ажилласан хараат бус гишүүнийг хараат бусад тооцохгүй;
 - 2.5.5. ТУЗ-ийн гишүүнийг улируулан сонгоход ТУЗ-ийн гишүүнээр ажилласан нийт хугацаа, өмнөх бүрэн эрхийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан зэрэг мэдээллийг танилцуулна.
- 2.6. ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох ба ба хамгийн олон тооны санал авсан нэр дэвшигчдийг ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсонд тооцно.
- 2.7. ТУЗ-ийн гишүүн нас барсан, удаан хугацаагаар үүргээ биелүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан бол Нэр дэвшүүлэх хороо яаралтай хуралдаж, орлох этгээдийг тодорхойлон, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн түр томилж болно.

2.8. Хэрэв ТУЗ-ийн гишүүдийн 50-иас илүү хувь нь ажиллах боломжгүй болсон бол ТУЗ-өөс шинэ ТУЗ байгуулах талаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлах шийдвэр гаргах ба ийнхүү гаргахаас өөр бусад шийдвэр гаргах эрхгүй.

3. ТУЗ-ийн гишүүдийн сургалт, хөгжил

3.1. ТУЗ-ийн гишүүнийг анх сонгогдоход компанийн танилцуулга, чиглүүлэх хөтөлбөрийг зохион байгуулах ба энэ нь ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох сургалтын агуулгатай байна. Үүнд дорх агуулга (зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй)-ыг бичгээр танилцуулж, гарын үсэг зуруулан баталгаажуулна. Үүнд:

3.1.1. компанийн үйл ажиллагаа ба санхүүгийн тайлан, танилцуулга;

3.1.2. компанийн засаглалын журмууд;

3.1.3. хараат бус гишүүний хувьд хараат бус байдал алдагдах нөхцөл байдал үүссэн тохиолдолд мэдэгдэх тухай;

3.1.4. компанийн мэдээлэлтэй харьцах дэг журам, нууцлалын үүрэг;

3.1.5. компанийн дотоод дүрэм, журмууд.

3.2. ТУЗ-ийн гишүүн нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ аваагүй бол даруй компанийн засаглалын сургалтад хамрагдана.

3.3. ТУЗ-ийн гишүүдийн мэдлэг, чадварыг тогтмол дээшлүүлэх, цаг үеийн мэдээллийг олгох сургалт, хөтөлбөрийг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо гаргаж, ТУЗ-ийн хурлаас баталснаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зохион байгуулна. Сургалтын хөтөлбөрт дараах агуулга хамаарах ба зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

3.3.1. компанийн ёс зүйн дүрэм журам;

3.3.2. авлига, албан тушаалын гэмт хэргээс сэргийлэх тухай;

3.3.3. дотоод мэдээлэл эзэмшигчид хориглох үйл ажиллагаа;

3.3.4. компанийн дотоод бодлого, дүрэм, журмууд;

3.3.5. компанийн засаглалын шилдэг туршлага.

3.4. ТУЗ-ийн гишүүнд зориулсан сургалт нь зайны, танхимын болон рэтрийт, бизнес аялал хэлбэртэй байж болно.

3.5. ТУЗ-ийн гишүүдийн сургалтын зардлыг компани бүрэн хариуцна.

4. ТУЗ-ийн гишүүдийн гүйцэтгэл, тайлагнал

4.1. ТУЗ болон түүний дэргэдэх хороод, ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд нь тус бүр жилийн эцэст нэг удаа гүйцэтгэлээ тайлагнаж, жилийн үйл ажиллагааны тайланд тусган, хувьцаа эзэмшигчид, олон нийтэд өөрийн цахим хуудсаар тайлагнана. Үүнд, тухайн ТУЗ-ийн гишүүний хуралдааны ирц, компанийн үйл ажиллагаанд ач холбогдол бүхий ажлын үр дүн зэрэг мэдээллийг дурдана.

4.2. ТУЗ болон түүний дэргэдэх хороод, гишүүдийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хөндлөнгийн этгээдээр гүйцэтгүүлж болно.

4.3. ТУЗ-ийн даргын ажлын гүйцэтгэлийн үнэлгээг аль нэг хараат бус гишүүн нь хариуцаж, бусад гишүүдийнхээ саналыг авсны үндсэн дээр гүйцэтгэнэ.

5. Бусад

5.1. Энэхүү журам нь ТУЗ-ийн баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

5.2. Энэ бодлогын хэрэгжилтэд Нэр дэвшүүлэх хороо хяналт тавьж ажиллана.

5.3. Шаардлагатай гэж үзвэл энэ бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах асуудлыг ТУЗ-өөс шийдвэрлэнэ.